



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/539

Өлгий


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.12 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2018 оны 7 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн усархаг ширүүн бороо орж Өлгий сумын 2, 3, 4, 9, 11, 12, 13 дугаар багуудад буусан үерийн улмаас үүссэн гамшгийн хор уршгийг арилгах нэн тэргүүний шаардлагатай арга хэмжээнд зарцуулагдах 25 058 117 /хорин таван сая тавин найман мянга нэг зуун арван долоон/ төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2. Зарцуулагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшгаас хамгаалах зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Х.Тилеген/-т зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс /Х.Ербол/-т үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА А. ТЫЛЫМХАН